



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 09 сарын 17 өдөр

Дугаар АЧАА

Улаанбаатар хот

Зочид буудал, дэн буудал, амралтын
газрын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл
олгох, цуцлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам"-ын 5.1, газрын дүрмийн 2.5.3-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Зочид буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS4588:2008" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын нэгдүгээр хавсралтад дурдсан аж ахуйн нэгжид зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

2. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Дэн буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS5738:2007" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын хоёрдугаар хавсралтад дурдсан аж ахуйн нэгжид Дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Проджи ХХК-ний "Атлас" зочид буудлын 16/049, Норлин очир ХХК-ний "Орд" дэн буудлын 13/291, Иргэн Л.Бурмаа "Мини" дэн буудлын 14/63 тоот гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

4. Гэрчилгээний үнэ болох 5000 /таван мянга/ төгрөгийг байгууллага болон иргэн тус бүрээс хураан, Төрийн сан банкны 100200051053 тоот дансанд төвлөрүүлэн, зөвшөөрлийн гэрчилгээний бичилт, олголтод байнгын хяналт тавьж ажиллахыг Ахлах нягтлан бодогч /Б.Батбаатар/-т даалгасугай.

5. Зөвшөөрөл авсан байгууллага болон иргэдтэй гэрээ байгуулж үр дүнг тооцон ажиллахыг Захиргааны хэлтэс /Д.Ганболд/-д үүрэг болгосугай.

Энэхүү тушаалыг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Нийслэлийн Цагдаагийн газар болон дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхийг Хяналт, шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн /Б.Отгонсууд/-д үүрэг болгосугай.

ДАРГА

D.Batsoy

Д.БАТСҮХ

1117139265
УОА0453 5284325

1150500272

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2017 оны 09 сарын 10
өдрийн дугаар тушаалын нэгдүгээр
хавсралт

1117139265
УОА0453 5284325

ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2017.09.12

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Проджи ХХК	5197406	Атлас	ХУД-ийн 10-р хороо Морингийн 89

-ооОо-

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2017 оны 09 сарын 10
өдрийн 10:30 дугаар тушаалын
хоёрдугаар хавсралт

1117139265
УОА0453 5284325

ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2017.09.12

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Иргэн Л.Бурмаа	Ш369052661	Мини	БГД-ийн 14-р хороо 18-1 байр
2	Норлин-Очир ХХК	5147964	Орд	БГД-ийн 5-р хороо ЭТӨЧ-13-р байр
3	Иргэн П.Анхмаа	ХК82112603	Роял	БЗД-ийн 22-р хороо Өлгийн 10-153

-ооОоо-